

МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНОЛЧ, ДОКТОР, ПРОФЕССОР
М.ЗУЛЬКАФИЛЬ

Т.Баасансүрэн*

* «Улаанбаатар-Эрдэм-Оюу» дээд сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор профессор

М. Зулькафиль 1989 онд Монголын сэтгүүл зүйн салбарын анхны шинжлэх ухааны доктор, нэрт эрдэмтэн, багш-сурган хүмүүжүүлэгч Г.Дэлэгийн удирдлагаар "Монголын орон нутгийн сонины нийтлэлийн үр нөлөөг дээшлүүлэх асуудалд" сэдвээр дэд эрдэмтний, 1997 онд ОХУ-ын Эрхүү хотын Улсын их сургуулийн профессор, хэл бичгийн шинжлэх ухааны доктор, нэрт сэтгүүл зүй судлаач В.П.Владимирцевийн удирдлагаар "Орчин үеийн Монголын сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлага: түүх, онол, практикийн асуудлууд" сэдвээр шинжлэх ухааны докторын зэргийг тус тус хамгаалсан байна. 1994 онд ЭЗЦОДЗ-ийн шийдвэрээр дэд профессор, 2004 онд МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр профессор цол хүртэж, 2011 онд ОХУ-ын Дорнод Сибирийн Боловсролын Академийн хүндэт доктор цол хүртжээ. Тэрээр мөн ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол судлалын нийгэмлэгийн хүндэт гишүүн.

Өнгөрсөн зуун жилд Монголын сэтгүүл зүйн онолын асуудлаар тогтож ажиллаж, тодорхой амжилтанд хүрсэн манай улсын цөөхөн эрдэмтний нэг нь

яах аргагүй М.Зулькафиль юм. Тэрбээр сүүлийн хорин жилд сэтгүүл зүйн тулгамдсан асуудлаар олон бүтээл туурвижээ.

Тухайлбал: "Өөрчлөлт шинэчлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл" (1994), "Орчин үеийн Монголын сэтгүүл зүй" (1997), "Сэтгүүл зүйн онолын үндэс" (I, II дэвтэр, 1999, 2000), "Чөлөөт хэвлэл: өчигдөр, өнөөдөр, маргааш" (2001, хамтын), "Эрэн сурвалжлах сэтгүүл зүй" (2002), "Сэтгүүл зүйн онолын зарим асуудал" (I, II, III, IV дэвтэр, 2002, 2006, 2008, 2012), "Сэтгүүлчийн ёс зүй" (2003, хамтын), "Сэтгүүл зүйн түүх" (2004), "Сэтгүүл зүйн тайлбар толь" (2005), "Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик" (2007), "АНУ-ын сэтгүүл зүйн түүх" (2007, хамтын), "Сэтгүүлчийн ур чадвар" (I, II, III боть, 2009, 2012), "Монголын олон нийтийн мэдээлэл: нэг намын үзэл суртлаас олон ургалч үзэл хүртэл" (2011) зэрэг нийтдээ 30 гаруй сурах бичиг, нэг сэдэвт зохиол, судалгааны ном, орчуулгын 6 ном, судалгааны 130 орчим өгүүлэл нийтлүүлсэн байна. Зарим бүтээл нь АНУ, ОХУ, БНХАУ, Япон, Казахстаны эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд нийтлэгджээ. Түүний "Сэт-

гүүлчийн ур чадвар" (I, II дэвтэр) сурах бичгийг ӨМӨЗО-нд монгол бичгээр хөрвүүлж, Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургууль зэрэг сэтгүүлч мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиуд сургалтанд ашиглаж байна. Тэрчлэн доктор М.Зулькафил нь өөрийн улсын болон олон улсын хэмжээний 40 гаруй эрдэм шинжилгээний хуралд оролцож, илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.

Профессор М.Зулькафил манай улсын сэтгүүл зүйгээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан гурван хүний нэг, сэтгүүл зүйн онолын асуудлаар шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан анхны эрдэмтэн юм. Түүний судалгааны бүтээлүүдээс гадаад, дотоодын 50 гаруй судлаач 250-иад удаа ишлэл авч, өөрсдийн бүтээлд ашигласан гэсэн тооцоо бий. Энэ бол түүний бүтээлийг хүлээн зөвшөөрч буйн нэг нотолгоо юм. Тэрээр 100 гаруй оюутны бакалаврын, 28 хүний магистрын, 5 хүний докторын ажлыг удирдан хамгаалуулж, нэг хүний шинжлэх ухааны докторын ажлын зөвлөхөөр ажилласан байна.

Профессор М.Зулькафил нь манай улсын сэтгүүл зүйн салбарын нэрт эрдэмтдийн нэг төдийгүй, сэтгүүл зүйн бакалавр, магистр, докторын түвшинд хичээл зааж, сэтгүүл зүйн мэргэжлийн стандарт, сургалтын төлөвлөгөө, хичээлийн тодорхойлолт, хөтөлбөрүүдийг боловсруулж, батлуулсан манай туршлагатай багш-сурган хүмүүжүүлэгч юм.

Түүний тэргүүлсэн багийн боловсруулсан "Сэтгүүлч" мэргэжлийн стандарт нь 2004 онд Монгол Улсын Стандарт хэмжил зүйн Үндэсний зөвлөлийн хурлаар батлагдсан дээд боловсролын анхны хоёр стандартын нэг бөгөөд өнөөдөр энэ стандартыг сэтгүүлч бэлтгэдэг бүх их, дээд сур-

гуульд мөрдөж байна. Доктор М.Зулькафилийн бичсэн "Сэтгүүл зүйн онолын үндэс", "Сэтгүүлчийн ур чадвар", "Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик", "Дэлхийн сэтгүүл зүйн түүх" зэрэг сурах бичиг хийгээд сэтгүүл зүйн сургалт-судалгааны чиглэлээр боловсруулсан бусад баримт бичгүүдийг сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиуд, сэтгүүл зүйн судалгааны байгууллагуудад өргөн ашиглаж байгааг нэмж дурдах нь зүйтэй болов уу.

Профессор М.Зулькафил МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимд багшилсан 30 гаруй жилийн хугацаанд 1300 гаруй сэтгүүлч, 100 гаруй сэтгүүл зүйн магистр, сэтгүүл зүйн докторыг бэлтгэн гаргахад голлох үүрэгтэй оролцож, сүүлийн 22 жилд МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийг удирдаж, түүний материаллаг баазыг бэхжүүлэх, манай орны сэтгүүл зүйн сургалт-судалгааны томоохон төв болгон хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хүн юм. Мөн Монголын сэтгүүлчдийн холбоо, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хорооны гишүүнээр удаа дараа сонгогдон ажиллаж байв. Тэрбээр сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагыг бэхжүүлэх, сэтгүүлч, уран бүтээлчдийн мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, эрх ашгийг хамгаалахад идэвх санаачилгатай ажиллаж ирсэн хүн билээ.

Профессор М.Зулькафил МУИС-ийн болон НШУС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, Сэтгүүл зүйн магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга, МУИС-ийн дэргэдэх Нийгмийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн, ШУА-ийн дэргэдэх Утга зохиол, хэл шинжлэл, сэтгүүл зүйгээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн

гишүүн, МУИС-ийн эрдэм шинжилгээний "Сэтгүүл зүй" сэтгүүлийн эрхлэгчээр ажилладаг.

Түүний хөдөлмөр бүтээлийг төр засгаас үнэлж "Алтангадас" одон (2000), ойн медалиудаар шагнаж, 2006 онд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээжээ.

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн дээд шагнал болох Жамсраны Цэвээний нэрэмжит шагнал, МСХ-ны болон МСНЭ-ийн нэрэмжит уран бүтээлийн шагнал, доктор Г.Дэлэгийн нэрэмжит шагналтай. Боловсрол, Шинжлэх ухаан, Хэвлэл мэдээллийн болон Радио, телевизийн тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнагдсан байна.

Профессор М.Зулькафиль Монгол Улсад сэтгүүлч боловсон хүчин бэлтгэх, сэтгүүл зүйн судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй эрдэмтэн судлаач, он удаан жил үр бүтээлтэй ажиллаж байгаа тэргүүний багш, сурган хүмүүжүүлэгчдийн нэг мөн болох тул түүний намтар, уран бүтээлийг тусгайлан судалж, нийтийн сонорт хүргэх цаг нэгэнт болжээ.

Миний бие 2009 онд түүний зарим бүтээлийн талаар тусгайлан бичиж "МОНЦАМЭ мэдээ" сонинд нийтлүүлсэн бөгөөд уг эрдэм шинжилгээний өгүүлэл эл ажлын эхлэл нь болсон юм. Түүнийгээ улам дэлгэрүүлж "Монголын сэтгүүл зүйн онолч, доктор, профессор М.Зулькафиль" гэдэг энэ номыг Монголын сэтгүүл зүйн 100 жилийн ойд зориулж бичлээ.

МУИС-ийн сэтгүүл зүйн ангийн оюутан Н.Цогзолмаа 2010 онд "Доктор М.Зулькафилийн судалгааны бүтээлийн онцлог" сэдвээр дипломын ажил бичсэнийг эс тооцвол түүний бүтээл туурвилыг ултайгаар судалсан нь үгүй юм.

Монголын сэтгүүл зүйн судлалыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд өөрийн гучин

жилийн бүтээл туурвилаа зориулж, бодитой, мэдэгдэхүйц хувь нэмэр оруулсан эрдэмтэн бол Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн, профессор доктор Маулетийн Зулькафиль яах аргагүй мөн.

Түүний судалж шинжилсэн сэтгүүл зүйн бүтээлүүдийг тоймлон

авч үзэж судлан нэг мөр ойлголт өгөх нь Монголын сэтгүүл зүйн судлалд багагүй ач холбогдолтой гэж үзэж байна.Энэ нь өнөө цагийн сэтгүүл зүйн залуу судлаачдад юуны түрүүнд нэн хэрэгтэй болно. Монголын сэтгүүл зүй үүсч хөгжөөд нэг зуун жилийн нүүрийг үзэж байна. Энэ хугацаанд цөөнгүй судлаач, шүүмжлэгчид төрж гарсан юм. Тэдний дунд М.Зулькафиль томоохон байр суурь эзэлнэ. Тийм учраас түүний судалгааны бүтээлүүдийг тусгайлан авч үзэх нь Монголын сэтгүүл зүйд хэрэгтэй бөгөөд М.Зулькафиль судлалын эхийг тавина гэдэгт итгэлтэй байна.

Ялангуяа доктор М.Зулькафилийн Монголын сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүдийг сэдэв чиглэлээр нь ангилах, сэтгүүл зүйн судлалд оруулсан түүний хувь нэмрийг нээн үзүүлж, эзлэх

«
*М.Зулькафилийн тэргүүлсэн
багийн боловсруулсан "Сэтгүүлч"
мэргэжлийн стандарт нь 2004 онд
Монгол Улсын Стандарт хэмжил
зүйн Үндэсний зөвлөлийн хурлаар
батлагдсан дээд боловсролын
анхны хоёр стандартын нэг бөгөөд
өнөөдөр энэ стандартыг сэтгүүлч
бэлтгэдэг бүх их, дээд сургуульд
мөрдөж байна.*
»

байр суурийг тодорхойлох, Монголд сэтгүүлч боловсон хүчин бэлтгэх үйлсэд тууштай хүчин зүтгэсэн сурган хүмүүжүүлэгч болох талаас нь авч үзэх нь илүү үр дүнтэй гэж бодож байна.

Өнгөрсөн гучаад жилд сэтгүүл зүйн чиглэлээр М.Зулькафилийн бүтээж туурвисан ном зохиолын нэрсийг дээр тоймлон өгүүлсэн. Харин зарим нэгийнх нь талаар нэмэлт мэдээлэл өгье. "Сэтгүүл зүйн онолын үндэс" I, II дэвтэр, "Сэтгүүл зүйн тайлбар толь", "Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик" зэрэг сурах бичгийг тэр туурвижээ. Энэ бол МУИС-д багшилж, сэтгүүл зүйн салбарт гучаад жил хүчин зүтгэснийх нь үр шим юм. Эдгээр бүтээлийг нь сэтгүүлч боловсон хүчин бэлтгэдэг Монголын бүх их, дээд сургуульд үндсэн хэрэглэгдэхүүн болгож ашиглаж байна.

"Сэтгүүл зүйн онолын үндэс" сурах бичиг нь гадаадын, ялангуяа ОХУ-ын их, дээд сургуулиудын сэтгүүлчийн ангид үздэг онолын сурах бичгүүд, судалгааны ном зохиолыг удирдлага болгон туурвиж, өөрийн орны сэтгүүл зүйн хөгжлийн онцлогтой холбож тайлбарласан сонирхолтой бүтээл юм. Уг бүтээлээс Монголын сэтгүүл зүйн өнөөгийн чиг хандлагыг олж үзэж, ил тод байдал, олон ургалч үзэл хэрхэн хөгжиж ирсэнтэй танилцаж болно. Мөн Монгол дахь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн систем, тэдгээрийн зохион байгуулалт, нийтлэл нэвтрүүлгийн сэдэв, агуулга, бичлэгийн төрөл зүйл, сэтгүүлчийн ур чадварт гарсан өөрчлөлтийг үзэж мэдэрнэ. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжлийн төлөвшил, чиг хандлагын асуудлыг ч хөндсөн байна.

Энэ номын талаар Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн хүндэт

ерөнхийлөгч асан Ц.Дашдондов "Зулькафиль олон ном бичсэн бүтээлч хүн. Түүний бичсэн номууд дэлгүүрийн лангуун дээр бус, сэтгүүлчдийн ширээн дээр байдаг. Тийм болохоор Зулькафилийн шавь нарыг МУИС-ийн сэтгүүл зүйн танхимын төгсөгчдөөр хэмжиж болохгүй. Номыг нь уншиж гэгээрсэн сэтгүүлчдийг ч түүний шавь гэж хэлэх ёстой" хэмээн өндрөөр үнэлжээ.

М.Зулькафиль нь "Чөлөөт хэвлэл: өчигдөр, өнөөдөр, маргааш", "Сэтгүүлчийн ёс зүй", "Дэлхийн сэтгүүл зүйн түүх", "Орчин үеийн Монголын сэтгүүл зүй" зэрэг нэг сэдэвт бүтээлүүд туурвижээ. Эдгээрээс "Орчин үеийн Монголын сэтгүүл зүй" бүтээлийг нь онцлон тэмдэглэж байна.

Доктор Ч.Чойсамбатай хамтран бичсэн "Сэтгүүлчийн ёс зүй" ном нь уг асуудлыг хөндөн бичсэн анхны бүтээлийн нэг юм. Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн сэдвийг манайд өнгөрсөн зууны наяд оны дунд үеэс ярьж эхэлсэн бөгөөд МСХ-ны ээлжит бүгд хурлаар анх удаа Монголын сэтгүүлчдийн ёс зүйн кодексийг баталж байсан түүхтэй билээ. Сүүлд 2005 онд сэтгүүлчдийн ёс зүйн зарчмыг шинэчилсэн бөгөөд 2011 онд Монголын сэтгүүлчдийн 15 дугаар их хурлаар зарчмын шинэчлэл хийж ёсчлон баталжээ.

Ёс зүйг эрхэмлэн дээдэлж, сэтгүүлчид өөрсдийн үйл ажиллагааны үндэс болгож хэвшүүлэхэд уг асуудлаар туурвисан эрдэмтдийн бүтээл туурвил чухал ач холбогдолтой юм. Сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн үүсэл, төлөвшил зэргийг онолын үүднээс тайлбарлаж, ёс зүйн тухай ойлголтыг дэлгэрэнгүй өгүүлснээрээ уг ном үнэтэй юм. Түүнчлэн сэтгүүлчийн эрх зүйн өнөөгийн байдал, сэтгүүл зүй дэх зохиогчийн эрх, мэдээлэл олж авах зөвшөөрөгдсөн ба хориотой аргууд, сэтгүүл-

чийн ёс зүйн алдаа, Монголын сэтгүүлчдийн ёс зүйн асуудал зэргийг хөндөж, зохиогчид өөрсдийн үнэлэлт дүгнэлтийг хийжээ.

Мөн "Дэлхийн сэтгүүл зүйн түүх" хэмээх нэг сэдэвт сайн бүтээл бий. Уг номд XX зууны үеийн дэлхийн сэтгүүл зүйн үүсэл, хөгжил, төлөвшлийн асуудлыг дэлгэрэнгүй тусгажээ. Дэлхийн улс орнуудын томоохон агентлагууд, медиа концернууд, олон хувиар хэвлэгддэг сэтгүүлүүд, дэлхийн анхны сонинуудын талаарх мэдээллийг хавсралт болгон оруулсан нь танин мэдэхүйн болон практик ач холбогдолтой болсон байна.

"Төрийн хэвлэлийн монополь эрх чөлөөт хэвлэлийн хөгжлийг хязгаарлаж байна", "Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн санал бодол", "Сэтгүүл зүй мэргэжил болон төлөвшсөн нь", "Бичлэгийн төрөл, зүйлийн зарим асуудал", "Монголын сэтгүүл зүй: чанар ба шаардлага", "Мэдээллийн иргэний нийгмийг төлөвшүүлэхэд мэдээлэл харилцааны хэрэгслийн үүрэг" зэрэг 100 гаруй эрдэм шинжилгээний өгүүллийг М.Зулькафиль туурвисан нь тухайн үеийн тогтмол хэвлэл, МУИС-ийн эрдэм шинжилгээний "Сэтгүүл зүй" сэтгүүлд хэвлэгдэж, нийт сэтгүүлч, судлаачдын хүртээл болжээ. Тухайлбал, "Тогтмол хэвлэлийн хэв маягийн ангилал, үндсэн ойлголтын зарим асуудал" эрдэм шинжилгээний өгүүлэлдээ тэрээр Монгол дахь тогтмол хэвлэлийн хэв маяг, ангиллын үндсэн категори, синхрон ба диахроны арга, мэдээллийн багтаамж гэсэн ойлголтуудыг авч үзсэн байх жишээтэй. Ийм өгүүллүүд олон бий.

М.Зулькафиль доктор Монголын сэтгүүл зүйн өнөөгийн хөгжлийн шинэ чиг хандлага болж буй чөлөөт хэвлэлийн онол, арга зүйн асуудлуудаар

хамгийн олон бүтээлийг туурвижээ. Мөн эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр өөрийн үгийг хэлж, тэрчлэн харьцангуй бага судлагдсан мэдээллийн эх сурвалж, телесэтгүүлчийн ур чадвар, эссе, зураглал зэрэг бичлэгийн төрөл зүйлүүдийн талаар ч үнэтэй санаа бодлоо хэлж, үнэлэлт дүгнэлт өгч ирсэн байна. Эдгээр өгүүлэл илтгэлүүдээ нэгтгэж "Сэтгүүл зүйн онолын зарим асуудал" дөрвөн цуврал ном болгон хэвлүүлжээ.

Мэргэжил нэгт гадаад, дотоодын эрдэмтэд тухайн судлаачийн бүтээлээс хэр зэрэг ишлэл авч өөрийн бүтээлдээ тусгасан, тэрчлэн гадаадын нэр хүндтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд бүтээл нь нийтлэгдсэн эсэхээр эрдэмтэн хүний ажлын үр дүнгийн гол үзүүлэлт болгож үнэлдэг нь практикт нэгэнт нийтлэг үзэгдэл болжээ.

Түүний судалгааны бүтээлүүд нь ОХУ, АНУ, БНХАУ, Япон, Казахстан зэрэг арваад орны эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд нийтлэгджээ. Тухайлбал: "Чөлөөт хэвлэлийн төлөвшил: эерэг ба сөрөг үзэгдлүүд" өгүүлэл нь ӨМИС-ийн эрдэм шинжилгээний бичигт (2007, №5), "Өөрчлөн байгуулалтын үеийн сэтгүүл зүй" өгүүлэл нь Казахстаны Соёл, мэдээллийн яамны Хэлний хорооны "Хэл ба нийгэм" сэтгүүлд (2006, №2), "The Formation of Free Press in Mongolia: Ethics and the Responsibilities of Journalists" өгүүлэл нь АНУ-ын Индианагийн Их сургуулийн Монгол судлалын төвийн "Mongol Survey" сэтгүүлд (2008 он, №21), "К вопросу формирования демократической журналистики в Монголии" өгүүлэл нь Москвагийн Улс түмний найрамдлын их сургуулийн "Литературоведение и журналистика" сэтгүүлд (2008, №2) тус тус нийтлэгдсэн байна.

Дээр дурдсан бүхнийг базан тэмдэглэж хэлэхэд Монгол оронд сэтгүүл зүйн судлал хөгжиж төлөвших, сэтгүүлч боловсон хүчин бэлтгэх ариун үйлсэд өөрийн бүтээл туурвил, хөдөлмөр зүтгэлээрээ жинтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн бол Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Шинжлэх ухааны үндэсний академийн жинхэнэ гишүүн, доктор, профессор Маулетиин Зулькафиль мөн гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Зарим зүйлийг тодотгож онцолбол:

- 1990 оноос хойш Монголын сэтгүүл зүйд гарсан өөрчлөлт, шинэчлэлийг онол, практик, арга зүйн үүднээс өргөн хүрээнд нэгтгэн дүгнэсэн эрдэмтэн бол М.Зулькафиль юм. Тэрээр Монгол дахь ОНМХ-үүд хэрхэн шинэчлэгдэж буй онцлог шинжийг судалж, сэтгүүл зүйн үүрэг, зарчим, бичлэгийн төрөл, зүйлүүд болоод чөлөөт хэвлэлийн тухай үзэл баримтлал, ойлголтод гарч байгаа өөрчлөлтийг нарийвчлан судалсан байна.

- МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимд болон манай орны сэтгүүл зүйн боловсролын системд хамгийн урт удаан хугацаанд тогтвортой ажиллаж, сэтгүүл зүйн сургалт, судалгааны ажлыг дагнан гүйцэтгэж байгаа шинжлэх ухааны доктор бол М.Зулькафиль болно. 1981 оноос өнөөг хүртэл МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхимд 32 дахь жилдээ багшаар, 1991 оноос хойш тус тэнхимийн эрхлэгчээр 22 дахь жилдээ үр бүтээлтэй ажиллаж байна.

- Түүний бүтээл туурвил, эрдэм шинжилгээний өгүүллүүд нь ОХУ, АНУ, БНХАУ, Япон, Казахстан зэрэг арваад орны эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгджээ. "Чөлөөт хэвлэлийн төлөвшил: зэрэг ба сөрөг үзэгдлүүд" өгүүлэл нь ӨМИС-ийн эрдэм шинжилгээний бичигт (2007, №5), "Өөрчлөн

байгуулалтын үеийн сэтгүүл зүй" өгүүлэл нь Казахстаны Соёл, мэдээллийн яамны Хэлний хорооны "Хэл ба нийгэм" сэтгүүлд (2006, №2) нийтлэгдсэн байх жишээтэй. Энэ нь М.Зулькафилийн бүтээлийн үнэ цэнийн илэрхийлэл мөн бөгөөд Монголын сэтгүүл зүйн онол, практикийн хөгжлийн түвшинг гадаадад харуулж буй бодит жишээ юм.

- "Сэтгүүл зүйн онолын үндэс", "Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик", "Сэтгүүлчийн ур чадвар", "Дэлхийн сэтгүүл зүйн түүх", "Орчин үеийн сэтгүүл зүй" зэрэг М.Зулькафилийн туурвисан бүтээлүүдийг Монголд сэтгүүлч бэлтгэдэг бүх их, дээд сургуульд өргөн ашиглаж байна. Энэ бол түүнийг сэтгүүл зүйн эрдэмтнийх нь хувьд төдийгүй, сэтгүүлч боловсон хүчин бэлтгэх сурган хүмүүжүүлэгчийнх нь хувьд нийтээр хүлээн зөвшөөрсний илрэл болно.

- Доктор, профессор М.Зулькафиль "Сэтгүүлчийн ёс зүй ба чөлөөт хэвлэл" төслийг 2002 онд "Чөлөөт хэвлэл" сангийн санхүүжилтээр, "Орон нутгийн хэвлэл, тулгамдсан асуудлууд" сэдэвт төслийг мөн "Чөлөөт хэвлэл" сангийн санхүүжилтээр, 2003 онд "Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санаа бодол" төслийг БНСУ-ын Азийн судалгааны төвийн санхүүжилтээр, "Экологийн боловсрол ба ОНМХ" төслийг Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр 2009 онд тус тус амжилттай хэрэгжүүлжээ. Доктор М.Зулькафиль нийтдээ арав орчим төслийн удирдагчаар ажилласан байна. Эдгээрийн үр дүнд 5 сурах бичиг, гарын авлага хэвлэгдэж, нэг стандарт бэлтгэгджээ.

- Сэтгүүл зүйн мэргэжлийн стандартыг боловсруулж, Стандартчлал хэмжил зүйн үндэсний зөвлөлөөр

батлуулсан байна. Энэ нь онцгой чухал ач холбогдолтой юм.

- "Орчин үеийн сэтгүүл зүй" бүтээл нь Монголын сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлагыг онолын үүднээс нэгтгэн дүгнэсэн анхны нэг сэдэвт зохиол болсон байна. М.Зулькафилийн энэхүү бүтээл нь орчин үеийн Монголын сэтгүүл зүйн үйл ажиллагааг түүний түүхэн хөгжлийн уламжлал, шинэчлэл, туршлага дээр тулгуурлан онол, практик, арга зүйн үүднээс иж бүрэн судалсан бүтээл юм. ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлгийн өнөөгийн байдал, чиг хандлага, хүрээ, шинэ үзэгдлүүдийг цогцоор нь задлан шинжилж нэгтгэн дүгнэжээ.

- "Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик" бүтээлдээ эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тухай ойлголт, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх орчин, нийгэмд гүйцэтгэх түүний үүрэг, баримтлах зарчим, эрэн сурвалжлага хийх аргууд, эх сурвалжийг товойлгон гаргажээ.

- Доктор М.Зулькафиль орос, англи,

турк, казах хэл дээрх эрдэм шинжилгээ судалгааны бүтээлүүдийг чөлөөтэй ашиглаж чаддаг давуу талаа чадмаг ашиглан Х.Андерсен, М.Мэллит нарын "Нийтлэл нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ?", Е.Мамбетказиевийн "ХХI зууны их сургууль: өөрчлөлт ба шинэчлэл", Д.Рэндаллын "Яаж сайн сэтгүүлч болох вэ?", Нил Гордоны "Сонголт", Н.Назарбаевын "Түүхийн давалгаанд" зэрэг номыг монгол хэл рүү хөрвүүлж нийтийн хүртээл болгосон байна. Түүний орчуулсан эдгээр бүтээл нь чөлөөт хэвлэл хөгжсөн гаднын улс орнуудын сэтгүүл зүйн үйл ажиллагааны туршлагаас суралцах, танин мэдэхүйн хүрээгээ өргөжүүлэн тэлэх боломжийг уншигчдад олгож байгаагаараа ач холбогдолтой юм.

Энэ бүхэн нь Монгол Улсад сэтгүүл зүйн судлалыг хөгжүүлэх хариуцлагатай, ёс зүйтэй, эрүүл сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд чухал түлхэц үзүүлж байгааг талархан тэмдэглэж байна.